# ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ДЭЭЛ ДЭЭР БРОКЕР, ДИЛЕР, АНДЕРРАЙТЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЭТГЭЭДЭД МӨРДӨГДӨХ НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ЗААВАР, ДАНСНЫ ЖАГСААЛТ, САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТОДРУУЛГЫН МАЯГТ

# Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын хамтарсан тушаал

- 1 дүгээр хавсралт - Үнэт цаасны зах зээл дээр брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн заавар
- 2 дугаар хавсралт - Дансны нэгдсэн жагсаалт
- 3 дугаар хавсралт - Санхүүгийн тайлан, тодруулгын маягт, загвар

# Санхүүгийн тайлан, түүний бүрэлдэхүүн хэсгүүд

- Санхүүгийн тайлангийн мэдэгдэл
- Санхүүгийн байдлын тайлан
- Орлогын дэлгэрэнгүй тайлан
- Өмчийн өөрчлөлтийн тайлан
- Мөнгөн гүйлгээний тайлан *(шууд аргаар)*
- Тайлбар тодруулга *(жилийн эцсийн тайланд)*

# Хөрөнгө

- Өнгөрсөн хугацааны үйл ажиллагааны үр дүнд үүсч бий болсон, байгууллагын эзэмшилд байгаа, ирээдүйд эдийн засгийн үр ашиг, үйлчилгээний чадавхиа өгөх нөөцийг *хөрөнгө* гэнэ.
  - Дангаараа буюу бусад хөрөнгөтэй хослон, шууд ба шууд бус замаар цэвэр мөнгөн гүйлгээ буюу үйлчилгээг нэмэгдүүлэх чадавхи бүхий ирээдүйн үр ашгийг агуулж байна;
  - Компани хөрөнгөөс олох үр ашигт хяналт тавьж чадахуйц байна;
  - Компани олсон үр ашгаа хянах буюу захирах эрх мэдлийг нэмэгдүүлэх ажил гүйлгээ хийгдэнэ.

# Эргэлтийн хөрөнгө

- Ашиглалтанд нь ямар нэг хязгаар тавигдаагүй мөнгө болон мөнгөтэй адилтгах хөрөнгө;
- Байгууллагын үйл ажиллагааны нэг циклийн хэвийн нөхцөлд хэрэгжихээр хүлээгдэж байгаа, эсвэл худалдан борлуулах ба ашиглахаар эзэмшиж байгаа;
- Худалдах зориулалттай юмуу богино хугацаатай эзэмшиж байгаа бөгөөд тайлангийн өдрөөс хойш арван хоёр сарын дотор хэрэгжихээр хүлээгдэж байгаа.

# Эргэлтийн хөрөнгө

- Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө
- Дансны авлага
- Татвар, НДШ-ийн авлага
- Бусад авлага
- Санхүүгийн хөрөнгө
- Бараа материал
- Урьдчилж төлсөн зардал/тооцоо
- Бусад эргэлтийн хөрөнгө
- Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө

# Эргэлтийн бус хөрөнгө

- Үндсэн хөрөнгө
- Биет бус хөрөнгө
- Урт хугацаат хөрөнгө оруулалт
- Хойшлогдсон татварын хөрөнгө
- Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө

# Өр төлбөр

- *Өр төлбөр гэж* компанийн үйл ажиллагаагаар бий болсон бусдын өмнө хүлээсэн эдийн засгийн үүрэг, хариуцлага юм.
- *Богино хугацаат өр төлбөр* гэдэг нь аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны циклийн хэвийн нөхцөлд төлбөр нь төлөгдөхөөр хүлээгдэж байгаа эсхүл тайлангийн өдрөөс хойш 12 сарын дотор төлбөр нь төлөгдөх өр төлбөрийг хэлнэ.

# Богино хугацаат өр төлбөр

- Дансны өглөг
- Цалингийн өглөг
- Татварын өглөг
- НДШ-ийн өглөг
- Богино хугацаат зээл
- Хүүний өглөг
- Ногдол ашгийн өглөг
- Урьдчилж орсон орлого
- Нөөц /өр төлбөр/
- Бусад богино хугацаат өр төлбөр
- Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгөнд хамаарах өр төлбөр

# Урт хугацаат өр төлбөр

- *Урт хугацаат өр төлбөр гэдэг* нь бизнесийн үйл ажиллагааны хэвийн цикл эсвэл нэг жилийн аль уртад төлөгдөхгүй буюу 1 жилийн дотор одоо байгаа эргэлтийн хөрөнгөөр барагдахгүй үүрэг хариуцлага юм.
  - Урт хугацаат зээл
  - Нөөц /өр төлбөр/
  - Хойшлогдсон татварын өр
  - Бусад урт хугацаат өр төлбөр

# Эздийн өмч

- Эздийн өмч нь тухайн мэргэжлийн байгууллагын нийт хөрөнгийн дүнгээс өр төлбөрийг хассан дүнтэй тэнцүү байна.
- *Оруулсан капитал /Хувь нийлүүлсэн хөрөнгө/ нь* капитал өмчийн хувьцаанд төлсөн буюу өөр ямар нэг байдлаар бизнест ашиглахын тулд хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгийн нийт дүнг хэлнэ. (хувьцаа, нэмж төлөгдсөн капитал)
- *Олсон капитал нь* ашигтай үйл ажиллагаа явуулсны үр дүнд нэмэгдсэн капитал. Энэ нь тухайн мэргэжлийн байгууллагын хуваарилагдаагүй нийт орлого  юм.

# Эздийн өмч

- Өмч (төрийн, хувийн, хувьцаат)
- Халаасны хувьцаа
- Нэмж төлөгдсөн капитал
- Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл
- Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц
- Эздийн өмчийн бусад хэсэг
- Хуримтлагдсан ашиг

# Орлого

- *Орлого ба олз* гэдэг нь компаний үйл ажиллагааны явцад тайлант хугацаанд бий болсон хөрөнгийн дотогш урсгал, өр төлбөр барагдуулалт болон өмчийн өсөлт хэлбэрээр эдийн засгийн өгөөж нэмэгдэхийг хэлнэ.
- Мэргэжлийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны явцад үүсэх өгөөж нь үндсэн үйл ажиллагааны орлого болно.

# Орлого

- Үндсэн үйл ажиллагааны орлого:
  - Брокер, дилерийн үйл ажиллагааны орлого
  - Андеррайтерийн үйл ажиллагааны орлого
  - Үнэт цаасны арилжааны цэвэр орлого
  - Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн цэвэр орлого
- Бусад орлого, олз:
  - Түрээсийн орлого,
  - Хүүний орлого,
  - Ногдол ашгийн орлого,
  - Эрхийн шимтгэлийн орлого
  - Бусад орлого

# Зардал

- *Зардал ба гарз* гэдэг нь үндсэн үйл ажиллагааг байнга явуулахын тулд бусад үйл ажиллагааг гүйцэтгэснээр хөрөнгө буурч өр төлбөр үүсэх явдал юм.
- Мэргэжлийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны явцад үүсэх үр ашгийн бууралт нь үйл ажиллагааны зардал болно.

# Зардал

- Үндсэн үйл ажиллагааны зардал
  - Борлуулалт, маркетингийн зардал
  - Ерөнхий ба удирдлагын зардал
  - Санхүүгийн зардал
- Бусад зардал, гарз
  - Гадаад валютын ханшийн зөрүүний гарз
  - Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз
  - Биет бус хөрөнгө данснаас хассаны гарз
- Татварын зардал

# Санхүүгийн хөрөнгө - Үнэт цаасаар оруулсан хөрөнгө оруулалт

- Богино хугацаанд ашиг олох зорилготой
- Өрийн болон өмчийн үнэт цаас, арилжааны багцад багтсан үнэт цаас
- Худалдан авснаас хойш 6 хүртэлх сарын хугацаанд эргүүлэн худалдах

**Арилжааны** (ашиг, алдагдалд бодит үнэ цэнийн зөрүүг хүлээн зөвшөөрөх)

- Тодорхой төлбөрийн хуваарьтай, тогтсон хугацаанд дуусгавар болох үнэт цаас (өрийн хэрэгсэл)
- Идэвхтэй зах зээлийн жишиг үнэтэй
- Хугацааг нь дуустал эзэмшихээр шийдвэрлэсэн ба ингэх боломжтой

**Хугацааны эцэс хүртэл эзэмших**

- Тодорхой төлбөрийн хуваарьтай, тогтсон хугацаанд дуусгавар болох үнэт цаас (өрийн хэрэгсэл)
- Идэвхтэй зах зээлийн жишиг үнэгүй
- Анх хүлээн зөвшөөрөхдөө арилжааны эсвэл борлуулахад бэлэн гэж ангилаагүй бай

**Зээл ба авлага**

- Бусад
- Өрийн ба өмчийн

**Борлуулахад бэлэн**

# Санхүүгийн хөрөнгө - Үнэт цаасаар оруулсан хөрөнгө оруулалт

**Арилжааны** (ашиг, алдагдалд бодит үнэ цэнийн зөрүүг хүлээн зөвшөөрөх)
→ **Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэн**
→ Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн орлого, зардал

**Хугацааны эцэс хүртэл эзэмших**
→ **Хорогдуулсан өртөг**
Ангилал өөрчлөхийг хориглоно

**Зээл ба авлага**
→ **Хорогдуулсан өртөг**
→ Хорогдуулсан өртөг - анхны өртгөөс төлөлтийг хасч, үр ашигт хүүгийн аргаар тооцоолсон урамшууллын хорогдуулалтыг хасах эсвэл хямдруулалтын хорогдуулалтыг нэмж, хуримтлуулан тооцсон хүүгийн авлагыг нэмнэ

**Борлуулахад бэлэн**
→ **Бусад дэлгэрэнгүй орлого болох бодит үнэ цэн**
→ Дахин үнэлгээний сан – Борлуулахад бэлэн үнэт цаас

# Бодит үнэ цэнэ

- 1-р түвшин: Үнэт цаасны идэвхтэй зах зээлийн жишиг үнэ (олон улсын болон дотоодын зах зээл дээр идэвхтэй арилжаалж буй үнэ)
- 2-р түвшин: Ижил төстэй санхүүгийн хэрэгслийн идэвхтэй зах зээлийн жишиг үнэ (шаардлагатай залруулгыг хийнэ)
- 3-р түвшин: Үнэт цаасны зах зээл идэвхтэй биш бол үнэлгээний аргыг ашиглана. Тухайлбал, дискаунтчилсан мөнгөн гүйлгээний шинжилгээ, опционы үнийн загвар гэх мэт (бэлэн олдохгүй мэдээлэл)
- Бодит үнэ цэнийг найдвартай тооцоолох боломжгүй бол өртгөөр

# Жишээ (Арилжааны үнэт цаас)

- Мэргэжлийн байгууллага 100,000.00 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 12 сарын хугацаатай, сарын 4,5%-ийн хүүтэй Засгийн газрын өрийн бичгийг 104,100 төгрөгөөр худалдан авсан. Үр ашигт хүүг (Internal Rate of Return) 4%-иар тооцоолсон.

1) Үнэт цаасыг худалдан авахад:

| | |
|---|---|
| Дебит: Засгийн газрын үнэт цаас | 104,100 |
| Кредит: Мөнгөн хөрөнгийн данс | 104,100 |

2) Сарын эцэст үнэт цаасны хүү төлөгдсөн бол:

| | |
|---|---|
| Дебит: Мөнгөн хөрөнгийн данс | 4,500 |
| Кредит: Хүүгийн орлого | 4,500 |

# Жишээ (Арилжааны үнэт цаас)

3) Тайлант сарын сүүлийн өдөр үнэт цаасыг бодит үнэ цэнээр нь дахин үнэлсэн ба 105,000 төгрөг байв:

| | |
|---|---|
| Дебит: Засгийн газрын үнэт цаас | 900 |
| Кредит: Үнэт цаасны үнэлгээний орлого | 900 |

4) Үнэт цаасыг 106,000 төгрөгөөр худалдсан бол:

| | |
|---|---|
| Дебит: Мөнгөн хөрөнгийн данс | 106,000 |
| Кредит: Үнэт цаасны арилжааны орлого | 1,000 |
| Кредит: Засгийн газрын үнэт цаас | 105,000 |

5) Үнэт цаасны үнэлгээний хэрэгжээгүй орлогыг хааж, тохируулав:

| | |
|---|---|
| Дебит: Үнэт цаасны үнэлгээний орлого | 900 |
| Кредит: Үнэт цаасны арилжааны орлого | 900 |

# Жишээ (Борлуулахад бэлэн үнэт цаас)

3) Тайлант сарын сүүлийн өдөр үнэт цаасыг бодит үнэ цэнээр нь дахин үнэлсэн ба 105,000 төгрөг байв:

| | |
|---|---|
| Дебит: Засгийн газрын үнэт цаас | 900 |
| Кредит: Үнэт цаасны дахин үнэлгээний сан | 900 |

4) Үнэт цаасыг 106,000 төгрөгөөр худалдсан бол:

| | |
|---|---|
| Дебит: Мөнгөн хөрөнгийн данс | 106,000 |
| Кредит: Үнэт цаасны арилжааны орлого | 1,000 |
| Кредит: Засгийн газрын үнэт цаас | 105,000 |

5) Дахин үнэлгээний санг хаав:

| | |
|---|---|
| Дебит: Үнэт цаасны дахин үнэлгээний сан | 900 |
| Кредит: Үнэт цаасны арилжааны орлого | 900 |

# Жишээ (Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас)

1) Үнэт цаасыг худалдан авахад

| | |
|---|---|
| Дебит: ХЭХЭҮЦ - Засгийн газрын үнэт цаас | 100,000 |
| Дебит: Үнэт цаасны урамшуулал | 4,100 |
| Кредит: Мөнгөн хөрөнгийн данс | 104,100 |

2) Үнэт цаасны хүү төлөгдсөн бол

| | |
|---|---|
| Дебит: Мөнгөн хөрөнгийн данс | 4,500 |
| Кредит: Үнэт цаасны урамшуулал | 336 |
| Кредит: Хүүгийн орлого | 4,164 |

3) Үнэт цаасны хугацаа дуусч, үндсэн төлбөр төлөгдсөн:

| | |
|---|---|
| Дебит: Мөнгөн хөрөнгийн данс | 100,000 |
| Кредит: ХЭХЭҮЦ - Засгийн газрын үнэт цаас | 100,000 |

# Жишээ (Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас)

- Үр ашигт хүүгийн аргаар тооцоолсон хүүгийн орлого, урамшууллын хорогдол

| | Хүү тооцох хугацаа | Хөрөнгө оруулалтын дансны дүн | Хүүгийн орлого | Нэрлэсэн хүүгийн төлбөр | Нэмэгдлийн хорогдуулалт | Хорогдуулаагүй нэмэгдэл |
|---|---|---|---|---|---|---|
| | | (a) | (b)=(a)*4% | (c)=100,000*4,5% | (d)=(c)-(b) | (e)=(a)-200,000 |
| 0 | 2012.01.01 | 104,100 | | | | 4,100 |
| 1 | 2012.01.31 | 103,764 | 4,164 | 4,500 | 336 | 3,764 |
| 2 | 2012.02.28 | 103,415 | 4,151 | 4,500 | 349 | 3,415 |
| 3 | 2012.03.31 | 103,052 | 4,137 | 4,500 | 363 | 3,052 |
| 4 | 2012.04.30 | 102,674 | 4,122 | 4,500 | 378 | 2,674 |
| 5 | 2012.05.31 | 102,281 | 4,107 | 4,500 | 393 | 2,281 |
| 6 | 2012.06.30 | 101,872 | 4,091 | 4,500 | 409 | 1,872 |
| 7 | 2012.07.31 | 101,447 | 4,075 | 4,500 | 425 | 1,447 |
| 8 | 2012.08.31 | 101,005 | 4,058 | 4,500 | 442 | 1,005 |
| 9 | 2012.09.30 | 100,545 | 4,040 | 4,500 | 460 | 545 |
| 10 | 2012.10.30 | 100,000 | 3,955 | 4,500 | 545 | 0 |
| | Нийт | | | 45,000 | | |

# СТОУС-ын дагуу тооцоолсон үнэт цаасны эрсдэлийн сангийн зардал

| Арилжааны (ашиг, алдагдалд бодит үнэ цэнийн зөрүүг хүлээн зөвшөөрөх) | Хугацааны эцэс хүртэл эзэмших | Зээл ба авлага | Борлуулахад бэлэн |
|---|---|---|---|

**Арилжааны** → Үнэ цэнийн бууралтыг тусгайлан тооцохгүй

**Хугацааны эцэс хүртэл эзэмших, Зээл ба авлага, Борлуулахад бэлэн** →

- Үнэ цэн буурсан гэх бодитой нотолгоо байгаа эсэх
- Эрсдэлийн сангийн зардал:
- = Дансны үнэ - Нөхөгдөх дүн
  - Нөхөгдөх дүнг борлуулах зардлыг хассан бодит үнэ цэн ба ашиглалтын өртөг (ирээдүйн мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэн)-ийн аль ихээр тодорхойлно.

# Хараат, хамтын хяналттай, охин компанид оруулсан хөрөнгө оруулалт

Хараат компани
*(мэдэгдэхүйц нөлөө 20%-50%)*
Хамтын хяналттай компани
*(хамтын хяналт)*

**Өмчийн аргаар**

- Анхны удаад өртгөөр хэмжинэ
- Дараа үеүдэд цэвэр хөрөнгөөс хүртэх хувийг тохируулна

- Цэвэр ашгаар өснө
- Ноогдол ашгаар буурна

Охин компани *(хяналт)*

**Өртгийн аргаар эсвэл Бодит үнэ цэнээр**

- Өртгийн аргаар хөрөнгө оруулалтыг өртгөөр хэмжинэ
- Зөвхөн үнэ цэнийн бууралтыг тохируулна

**Нэгтгэсэн санхүүгийн тайлан**

Нэгтгэсэн санхүүгийн тайланд өртгөөр нь толилуулна

# Жишээ (Өмчийн арга)

- Мэргэжлийн оролцогч Blue Widgets Corporation компанийн хувьцааны 30%-ийг 100 сая төгрөгөөр худалдан авсан. Тайлант жилд Blue Widgets Corporation компани нийт 10 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласнаа тайлагнаж, саналын эрхтэй бүх хувьцаа эзэмшигчиддээ 4 сая төгрөгийг ногдол ашигт хуваарилсан.
- 1) Хөрөнгө оруулалтыг анх бүртгэхдээ

Дебит: Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт 100 сая

Кредит: Мөнгөн хөрөнгө 100 сая

- 2) Хараат компанийн тайлагнасан цэвэр ашгаас хувь тэнцүүлэн тохируулга хийсэн (10 сая*30%)

Дебит: Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт 3 сая

Кредит: Хөрөнгө оруулалтын орлого 3 сая

- 3) Хараат компанийн зарласан ноогдол ашгийг хөрөнгө оруулалтаа бууруулж бүртгэнэ (4 сая*30%)

Дебит: Мөнгөн хөрөнгө 1,2 сая

Кредит: Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт 1,2 сая

Анхаарал тавьсанд баярлалаа